

**ТӨРӨӨС ОЛГОХ УРАМШУУЛЛААС НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОЛОН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ СУУТГАН ТӨЛӨХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН ТАЛААРХ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 04 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, А.Адъяасүрэн, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Н.Ганибал, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн, Л.Мөнхбаатар нараас 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Б.Бейсен, Ц.Идэрбат, Б.Саранчимэг нар ажиллалаа.

Байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Ажлын хэсгээс манай улсад 2022 оны байдлаар нийгмийн даатгалд хамрагдвал зохих малчдын тоо 238,329 байдгаас 48,800 буюу 20.5 хувь нь сайн дурын даатгалд даатгуулсан, эрүүл мэндийн даатгалд 141,400 малчин хамруулахаас 49,200 буюу 34,8 хувь нь хамрагдсан байгааг танилцуулж, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаа нь ирээдүйд эдгээр иргэдийн нийгмийн баталгаа алдагдаж, улмаар халамжийн зардал өсөх, улсын төсөвт ачаалал нэмэгдүүлэх тул хамрах хүрээг өргөтгөх арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэн хуулийн төслийн үзэл баримтлалыг алдагдуулахгүйгээр зарчмын зөрүүтэй 8 санал, найруулгын шинжтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



П.АНУЖИН